



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.02.29 № 03/267

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр зарласан НХААГ/20240103147 дугаартай “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс техникийн тодорхойлолттой холбогдуулан ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Мөн тендер шалгаруулалтын зааврын 37.1-т гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд тендерийн баримт бичиг дээр урьдчилгаа төлбөр олгохгүй гэж заасан. Дундын болон эцсийн тайлан гаргах бүрд гэрээний үнийн дүнг хувааж өгөх эсэхийг гэрээний төвшинд тохиролцох боломжтой.

Тендер шалгаруулалтын зааврын 9.4-т Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно. Тендер шалгаруулалтын заавартай сайтар танилцаж, тендерт оролцохыг хүсье.